

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН**

ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХЭТ ЖИЖИГЛЭСЭН, ТУХАЙН БАЙГУУЛЛАГЫН
ТӨСӨВТ ТУСГАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ЗАРДАЛД БОЛОН
ЗОРИУЛАЛТ БУС ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ТУС
САНГИЙН МӨН ЧАНАР, ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: СЭА-2022/30-16-ШТА-ГА

Сүхбаатар сум 2022 он



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Аудитор Ж.Цогт

Утас: 70363036 Цахим хаяг: tsogtj@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Утас: 70362442 Цахим хаяг: chuluuntsetsegd@audit.gov.mn

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх?

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?

Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх?

2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр нөлөөтэй байна уу?

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна уу?

Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх?

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?

Дүгнэлт

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт

Хүснэгт 2. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл

Хүснэгт 3. ОНХС-ийн хуваарилалт

Хүснэгт 4. Санал ирээгүй төсөл, арга хэмжээ

Дүрслэлийн товъёг:

Дүрслэл 1. ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг

Дүрслэл 2. Аймаг, сумын ОНХС-ийн 2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл

Дүрслэл 3. Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл

Дүрслэл 4. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл

Хавсралтын товъёг:

Хавсралт-1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт-2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт-3. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт-4. Магадалшгүй ажлын тэмдэглэл үйлдээгүй төсөл арга хэмжээ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын баримт материал болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт *MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”*, *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”*, *MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”*, *MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”*-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын

шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор Ж.Цогт, Д.Чулуунцэцэг, О.Анхбаяр нар 2022 оны 04 дүгээр сарын 21-нээс 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж **орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор** улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаанд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байсан бол уг журмыг 2021 оны 86 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ.

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн баталсан “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 10,042.5 сая төгрөгөөр баталсан бол 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ОНХНС болон улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 299.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10,341.5 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд хийсэн хэлэлцээрийн дагуу “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлж, хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай” хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2021 онд Сэлэнгэ аймгийн сумдын ОНХС-д 136.8 сая төгрөгийн дэмжлэг, 304.1 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.

Тус системд оруулсан 2021 оны мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэхэд 2021 онд аймгийн хэмжээнд 65 ажлын гүйцэтгэл 78 хувь, үүнээс тайлант онд ашиглалтад орох 56 ажил байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын төлөвлөгөө хөтөлбөрөөр 2021 онд хэрэгжүүлсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт 5,655.0 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах албан шаардлага, аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт нийт 11 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРЭН БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨӨГҮЙ БӨГӨӨД АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ИРГЭДИЙН САНАЛГҮЙГЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэрээс бүрэн төвлөрүүлэхээр төлөвлөөгүй байна.

1.1.1 “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 10,042.5 сая төгрөгөөр баталсан бол 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 299.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10,341.5 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

1.1.2 Аймаг, сумдын ИТХ-аас аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны эх үүсвэрт ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс /суурь зардлын хамт/ 10,341.5 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 1,762.9 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагын хандиваас 1,430.0 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 139.9 сая төгрөг зэрэг нийт **13,674.3 сая төгрөгийг** бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт /сая төгрөг/

№	Аймаг, сумдын нэр	ОНХНС болон улсын төсвөөс			Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр			Нийт эх үүсвэр
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	"Тогтвортой амьжиргаа-3" төсөл		ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	Хандив тусламж	Малын тоо, толгойн албан татвар	
			Урамшуу- лал	Дэмжлэг				
1	Алтанбулаг	93.6	19.5	5.0	44.4	10.0		172.5
2	Баруунбүрэн	126.4	15.8	6.5	73.1			221.8
3	Баянгол	219.9	30.0	7.8	4.7			262.4
4	Ерөө	342.7	32.5	13.4	52.5	500.0		941.1
5	Жавхлант	56.6	10.5	2.7	15.9			85.7
6	Зүүнбүрэн	58.2		3.0	8.5			69.7
7	Мандал	771.7	90.6	37.4	145.2			1,044.9
8	Орхон	78.8	14.5	3.8				97.1
9	Орхонтуул	201.5	29.3	7.6	162.1			400.5
10	Сайхан	204.5	25.6	10.6	14.5		20.0	275.2
11	Сант	89.0	14.4	3.7	13.5			120.6
12	Сүхбаатар	221.8		11.6	98.7			332.1
13	Түшиг	76.7	8.6	4.3	151.9			241.5
14	Хушаат	78.4		3.5	10.6			92.5
15	Хүдэр	140.3	12.8	5.3	56.1			214.5
16	Цагааннуур	149.9		7.7	7.7		119.9	285.2
17	Шаамар	57.2		2.9	0.3			60.4
18	Аймгийн ОНХС	6,933.4			903.2	920.0		8,756.6
	НИЙТ	9,900.6	304.1	136.8	1,762.9	1,430.0	139.9	13,674.3

Эх сурвалж: МУ-ын 2021 оны төсвийн тухай хууль, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.1.3 Гүйцэтгэлээр 2021 онд ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс 10,341.5 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 162.4 сая төгрөг, дотоод, гадаадын хандив тусламжаас 10.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 219.2 сая төгрөг

зэрэг нийт **10,733.1** сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээр орлогын төлөвлөгөө 78.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл /сая төгрөг/

№	Аймаг, сумдын нэр	ОНХНС болон улсын төсвөөс			Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр			Нийт эх үүсвэр
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	"Тогтвортой амьжиргаа-3" төсөл		ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	Хандив тусламж	Бусад орлого	
			Урамшуу- лал	Дэмжлэг				
1	Алтанбулаг	93.6	19.5	5.0	-	10.0		128.1
2	Баруунбүрэн	126.4	15.8	6.5	-			148.7
3	Баянгол	219.9	30.0	7.8	-			257.7
4	Ерөө	342.7	32.5	13.4	-			388.6
5	Жавхлант	56.6	10.5	2.7	4.4			74.2
6	Зүүнбүрэн	58.2		3.0	7.4			68.6
7	Мандал	771.7	90.6	37.4	-			899.7
8	Орхон	78.8	14.5	3.8				97.1
9	Орхонтуул	201.5	29.3	7.6	31.8			270.2
10	Сайхан	204.5	25.6	10.6	-			240.7
11	Сант	89.0	14.4	3.7	-			107.1
12	Сүхбаатар	221.8		11.6	-			233.4
13	Түшиг	76.7	8.6	4.3	116.1			205.7
14	Хушаат	78.4		3.5	2.7			84.6
15	Хүдэр	140.3	12.8	5.3	-			158.4
16	Цагааннуур	149.9		7.7	-			157.6
17	Шаамар	57.2		2.9	-			60.1
18	Аймгийн ОНХС	6,933.4			-		219.2	7,152.6
	НИЙТ	9,900.6	304.1	136.8	162.4	10.0	219.2	10,733.1

Эх сурвалж: Аймаг, сумын ОНХС-ийн харилцах дансны хуулууд

1.1.4 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Алтанбулаг сумын ОНХС-д “Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-аас 10.0 сая төгрөг, Ерөө суманд “Болд төмөр Ерөө гол” ХХК-иас 500.0 сая төгрөг, аймгийн ОНХС-д ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 920.0 сая төгрөг зэрэг нийт 1,430.0 сая төгрөгийн хандивын орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс зөвхөн Алтанбулаг сумын ОНХС-д 10.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрсөн байна.

1.1.5 Дараах сумд, тосгон нь иргэн, аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.2.5¹ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:


- Мандал сум “Нугын хишиг” ХХК-иас 10.0 сая төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатаас 40.0 сая төгрөг зэрэг нийт 50.0 сая төгрөгийн хандивын орлогыг “Мандал сумын хөгжлийн төлөө хамтдаа” НҮТББ-ын дансанд,
- Бугант тосгон зам засварын ажилд зориулан “БТЕГ” ХХК-иас хандивласан 54.0 сая төгрөгийг Захирагчийн албаны нэмэлт санхүүжилтийн дансанд,

¹ 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

- Зүүнбүрэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-ний дагуу төвлөрсөн 49.8 сая төгрөгийг “Илдэн бүрэн” ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж, зарцуулсан гэх мэт.

1.1.6 Гүйцэтгэлээр аймаг, сумдын ОНХС-д ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийг график дүрслэлээр харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 1. ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг /сая төгрөг/



1.1.7 Нийт эх үүсвэрийн 5,576.4 сая төгрөг буюу 53.9 хувийг ОНХНС-аас, 4,324.2 сая төгрөг буюу 41.8 хувийг улсын төсвөөс, 440.9 сая төгрөг буюу 4.3 хувийг Тогтвортой амьжиргаа-3 төслөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

1.1.8 ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрээс Сэлэнгэ аймагт хуваарилсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2², 59.3³, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. ОНХС-ийн хуваарилалт /сая төгрөг/

д/д	Санхүүжилт олгох аймаг, сумд	ОНХНС-аас					ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс		Тогтвортой амьжиргаа 3 төслөөс		Орлогын шилжүүл- гийн дүн
		Сумын ОНХС			Суурь зарл- ага	Аймгийн ОНХС	АМХТЗ	АМАТЗ	Урам- шуул ал	Дэм жлэг	
		Хүн ам 40%	Алсл- алт 30%	Нутаг дэвсгэ р 30%							
1	Алтанбулаг	46.5	6.7	40.4					19.5	5.0	118.1
2	Баруунбүрэн	30.3	40.0	54.1			2.0		15.8	6.5	148.7
3	Баянгол	54.5	57.3	38.0			6.6	63.5	30.0	7.8	257.7
4	Ерөө	66.9	36.2	157.6			22.6	59.4	32.5	13.4	388.6
5	Жавхлант	19.3	7.5	22.9			6.9		10.5	2.7	69.8
6	Зүүнбүрэн	27.6	7.4	23.2						3.0	61.2
7	Мандал	264.4	365.2	93.1	77.3		0.0	49.0	90.6	37.4	977.0
8	Орхон	22.4	23.6	25.1			7.1	0.6	14.5	3.8	97.1
9	Орхонтуул	36.7	53.0	56.5			30.1	25.2	29.3	7.6	238.4
10	Сайхан	91.1	87.5	25.2	38.9			0.6	25.6	10.6	279.5
11	Сант	20.6	23.5	26.7			18.2		14.4	3.7	107.1
12	Сүхбаатар	220.9	0.0	0.9	25.1					11.6	258.5
13	Түшиг	17.9	14.6	47.9				4.9		4.3	89.6

² Аймаг, нийслэл нь ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах.

³ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно: 59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс; 59.3.2.хүн амын тоо; 59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

14	Хушаат	20.2	10.9	38.6				8.7	3.5	81.9
15	Хүдэр	26.5	25.5	54.6			16.5	17.3	12.7	158.4
16	Цагааннуур	49.7	26.9	73.3					7.7	157.6
17	Шаамар	39.1	5.2	12.9			0.1		2.9	60.2
18	Аймгийн ОНХС				341.2	6,450.9				6,792.1
Нийт дүн		1,054.6	791.0	791.0	482.5	6,450.9	110.0	220.6	304.1	10,341.5

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

1.1.9 Дээрх хүснэгтээс харахад ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн 65.7 хувь буюу 6,792.1 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 34.3 хувь буюу 3,549.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

1.1.10 Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу усан хангамжийн үйлчилгээнд 21.7 сая төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээнд 319.5 сая төгрөг, сумдын хот тохижуулах зардалд 141.3 сая төгрөг зэрэг нийт **482.5** сая төгрөгийн суурь зарлагыг хуваарилсан байна.

1.1.11 Монгол Улсын 2021 оны төсвийн тодотголоор аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг **299.0** сая төгрөгөөр нэмэгдүүлснийг зөвхөн аймгийн ОНХС-д үлдэх орлогын шилжүүлэгт хуваарилсан байна.

Дүрслэл 2. Аймаг, сумын ОНХС-ийн 2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх сурвалж: Аймаг, сумын ОНХС-ийн харилцах дансны хуульгууд

1.1.12 Тайлант онд гүйцэтгэлээр ОНХНС болон улсын төсөв, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс аймаг, сумдын ОНХС-ийн шилжүүлэг болон суурь зардалд 10,341.5 сая төгрөг буюу санхүүжилтийг бүрэн олгосон боловч аймгийн Мал эмнэлгийн газраас мал эмнэлгийн үйлчилгээний зардлын хэмнэлт 2.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн дансанд буцаан төвлөрүүлснээс шалтгаалж, ОНХС-ийн санхүүжилт 10,338.8 сая төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

1.1.13 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁴, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг

⁴ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 60.2.2.энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө, 60.2.4.татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, 60.2.5.тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, 60.2.8 малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын

тооцох аргачлал"-ын 2.2-т ОНХС нь 5 төрлийн эх үүсвэрээс бүрдэхээр заасан боловч аймаг, сумдууд дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Орхон сум нь зөвхөн ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрээр,
- Аймаг болон Алтанбулаг, Ерөө, Сайхан, Цагааннуур сумд нь ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг, урьд оны үлдэгдэл, хандив тусламж гэсэн 3 эх үүсвэрээр,
- Бусад 12 сум нь ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг, урьд оны үлдэгдэл гэсэн 2 эх үүсвэрээр тус тус бүрдүүлэхээр гэх мэт.

1.1.14 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тусгасан бөгөөд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15 дахь заалтын дагуу “Малын тоо толгойн албан татвар”-ыг сумын төсвийн орлогод төвлөрүүлж, 60 дугаар зүйлийн 60.2.8⁵-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр байхаар тусгасан байна.

1.1.15 Гэвч коронавируст цар тахлын улмаас иргэдийн орлого хомсдож, эдийн засгийн хүндрэл үүсэж байгаатай холбогдуулан Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл малын хөлийн татварыг “0” хувиар тогтоох буюу чөлөөлөх зөвлөмжийг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ-т хүргүүлсэн байна.

1.1.16 Малын тоо толгойн албан татвараас бүрдсэн орлогыг зарцуулах чиглэлийг тодорхойлсон “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсанаас шалтгаалан Сайхан, Цагааннуур сумаас бусад сумд нь ОНХС-ийн төлөвлөлтөд уг орлогыг тусгаагүй байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бүх төсөл, арга хэмжээг иргэдийн санал авалгүйгээр төлөвлөж, баталсан байна.

Аймгийн ОНХС:

1.2.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр нийт 8,274.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 67 төсөл, арга хэмжээг эцэслэн баталсны 1,383.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 6,890.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 нь шинээр эхлэх төсөл арга хэмжээ байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав/

тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

⁵ малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

1.2.2 Аймаг нь ОНХС-ийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн дагуу төлөвлөөгүй байна.

1.2.3. Өөрөөр хэлбэл ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулаагүйгээс сумдаас ирүүлсэн төсөл, арга хэмжээг иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн болон аймгийн хөгжлийн бодлого чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэхийг тооцох, урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэх, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажил огт хийгдээгүй байна.

1.2.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах дараах төсөл, арга хэмжээг */давхардсан өртгөөр/* аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Иргэдийн саналыг аваагүй 5,840.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл, арга хэмжээ */ баяр наадмаас бусад шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бүх төсөл, арга хэмжээ/*
- Удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх */ “Коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах”- төсөл, арга хэмжээнд 620.8 сая төгрөг, Баруунбүрэн суманд “Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих”-д 100.0 сая төгрөг, Шаамар сумын сургуулийн засварын зураг төсөвт 15.0 сая төгрөг/ зорилго бүхий төсөл, арга хэмжээнд 735.8 сая төгрөг,*
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал */Аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт хамрын дурангийн тоног төхөөрөмж худалдан авах 80.0 сая төгрөг, аймгийн нэгдсэн эмнэлгийн засварт 50.0 сая төгрөг, “Статистикийн хэлтэст автомашин авах 50.0 сая төгрөг /-д 180.0 сая төгрөг.*

1.2.5 Аймгийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт 3,397.8 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээний зураг, төсөв, тооцоо, судалгааг батлуулсны дараа батлагдсан өртөгт нь багтаан гүйцэтгэсэн буюу зураг, төсөв, тооцоо, үнийн судалгааг урьдчилан хийлгүйгээр баталсан нь */зураг, төсөв шаардлагатай 2,359.8 сая төгрөгийг 18 төсөл, арга хэмжээ, тооцоо судалгаа хийх шаардлагатай 1,038.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ/* Төсвийн тухай хуулийн 29.4⁶, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3⁷ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав/*

Сумдын ОНХС:

1.2.6 Сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр нийт 4,917.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 130 төсөл, арга хэмжээг эцэслэн баталсны 332.4

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 нь өмнөх оноос шилжсэн бол 4,584.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 нь шинээр эхлэх төсөл арга хэмжээ байна.

1.2.7 Багуудын ИНХ-аас ирүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, эрэмбэлэлттэй холбоотой баримт материалыг тулган баталгаажуулахад хугацаандаа хуралдаагүй, ирц бүрдээгүй, төслийн танилцуулгыг бэлтгээгүй, саналын маягыг бүрэн хөтлөөгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.3⁸, 5.7⁹, 5.8¹⁰, 5.13¹¹ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- *Хууль журамд заасан хугацаанд хуралдаагүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 1/ – 1 сумын 3 баг,*
- *Иргэдийн саналыг хүчингүй болсон маягтаар авсан /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 1/ - 1 сумын 3 баг,*
- *Санал өгсөн иргэдийн тоог сонгуулийн нийт хүн амын тоотой харьцуулаагүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 2/ - 3 сумын 12 баг,*
- *Төслийн хэрэгцээ, шаардлага, иргэдийн амьдралд нөлөөлөх нөлөөлөл, хэрэгжих төсөл, арга хэмжээнээс үр өгөөж хүртээгсдийн тоог тооцоогүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 5/ - 10 сумын 27 баг,*
- *Ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцсон /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 5/ - 6 сумын 16 баг,*
- *Батлагдсан төслийн танилцуулгыг бэлтгээгүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 7/ - 7 сумын 18 баг.*

1.2.8 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг Жавхлант, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр, Шаамар зэрэг сумдууд 2020 оны 5-9 дүгээр сард байгуулсан нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.1¹² дэх заалтыг зөрчсөн байна.

1.2.9 Баянгол, Мандал, Орхон, Сүхбаатар, Түшиг, Хушаат, Шаамар сумын ЗДТГ-ын ажлын хэсэг иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар, тодруулга бэлтгээгүй нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.4.2 дахь заалтыг зөрчсөн байна.

⁸ Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан жишиг маягыг баг, хорооны өрх бүрд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягын дагуу бүртгэж нэгтгэнэ.

⁹ Баг, хорооны Засаг дарга энэ журмын 5.6-д заасны дагуу иргэдээс авсан саналыг нэгтгэн урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтад багтсан үзүүлэлтийг ирсэн санал бүрийн хувьд боловсруулах ба энэ журмын 5.1-д заасан танилцуулгад үндэслэн мэдээлэл бэлтгэж, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал /цаашид ИНХ гэх/-д оруулж хэлэлцүүлнэ.

¹⁰ Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

¹¹ Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг энэ журмын 5.12-т заасан санал өгсөн иргэдийн тоог баг, хорооны сонгуулийн насны иргэдийн нийт тоонд харьцуулсан харьцаагаар эрэмбэлсэн тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг ИНХ-ын тогтоолоор батална.

¹² Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна.

1.2.10 Бүх сумдууд аймгийн ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг бэлтгэж, аймгийн Засаг даргад хүргүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.6 дах заалтыг зөрчсөн байна.

1.2.11 Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 221.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн байна. Үүнд :

- Ерөө сум “Хогийн цэг цэвэрлэх хашаажуулах /Буурагчин баг/”, “Төрийн албан хаагчийн байр барих /Бугант/”, “Төрийн албан хаагчийн байр барих /Ерөө/”, “15 хүүхдийн сургалтын төлбөр” зэрэг 4 төсөл, арга хэмжээнд 139.8 сая төгрөгийн,
- Орхонтуул сум “Баянцогтын 2-р багт Ёслол хүндэтгэлийн өргөө барих”, “Баянцогтын 2-р багт лед дэлгэц худалдан авах”, “Баянцогтын 2-р багийн Туулын ундарга зоогийн газрын дээвэр, сантехникийн засвар хийх” зэрэг 3 төсөл, арга хэмжээнд 61.2 сая төгрөгийн,
- Сайхан сум “Малын тоо, толгойн албан татварын орлогын зарцуулалт” гэх 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ гэх мэт.

1.2.12 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 130.2 сая төгрөгийн дараах 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Ерөө сум, Бугант тосгонд “Төрийн албан хаагчийн байр барих” 2 төсөл, арга хэмжээнд нийт 80.0 сая төгрөг,
- Ерөө сумын “15 хүүхдийн сургалтын төлбөр”-т 45.0 сая төгрөг,
- Түшиг сум нь “Ойн менежментийн төлөвлөгөө” хийлгэхэд 5.2 сая төгрөг.

1.2.13 Сумдын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт 2,038.9 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээний өртөг, үнийн тооцоо, судалгааг урьдчилан хийлгүйгээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4¹³, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3¹⁴ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав/ Үүнд:

- 1,847.1 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээний зураг, төсвийг батлуулсны дараа гүйцэтгэсэн /зураг, төсөв шаардлагатай 1,298.2 сая төгрөгийг 11 төсөл, арга хэмжээ, тооцоо судалгаа хийх шаардлагатай 548.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ/
- 191.8 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээнд үнийн судалгаа, төсөв, тооцоо огт хийгээгүй гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 44.1 ХУВЬ НЬ ДУТУУ БОЛОН ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.


Аймгийн ОНХС:

¹³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

2.1.1 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр нийт 8,274.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 67 төсөл, арга хэмжээ /1,383.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 6,890.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 нь шинээр эхлэх/ төсөл арга хэмжээ баталснаас 3,955.2 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээ бүрэн / гэрээний үнээр /, 1,673.5 мянган төгрөгийн 15 төсөл арга хэмжээ / гэрээний үнээр/ дутуу хэрэгжиж, 2,540.0 мянган төгрөгийн 16 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-аас харах/

Дүрслэл 3. Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



2.1.2 2021 онд шинээр хэрэгжүүлэх нийт 6,890.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 4,919.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-оос харах/ Үүнд:

- 2,840.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 2,024.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний аргаар,
- 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар гэх мэт.

2.1.3 Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн, захиалагч байгууллагаас худалдан авах ажиллагааг явуулахад шаардлагатай баримт, материал, зураг төсөв ирүүлээгүй, хандивын эх үүсвэр бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас 1,150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Үүнд:

- Шилэн гүүр барих 700.0 сая төгрөг,
- Алтанбулаг сумын уурын зуухны шинэчлэл 100.0 сая төгрөг,
- Өрхийн эмнэлэг, цагдаа, ахмад, багийн нэгдсэн байр барих /Сүхбаатар сум, 3-р баг/ 200.0 сая төгрөг,
- Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих /Баруунбүрэн сум / 100.0 сая төгрөг

- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Статистикийн хэлтэст машин худалдан авах төсөл, арга хэмжээ.

2.1.4 Худалдан авах ажиллагааг тус бүр 2-7 удаа зохин байгуулсан боловч санал ирээгүй гэх үндэслэлээр 894.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Санал ирээгүй төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	ХАА-нд мөрдсөн арга	Зарласан удаа
1	Орхонтуул сум үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ой угтаж баяр наадмын талбай байгуулах /Орхонтуул сум/	150.0	НТШ	2
2	Могойтын аманд зам, гэрэлтүүлэг тавих /Сүхбаатар сум, 2-р баг/	200.0	НТШ	2
3	Уурын зуухны засварын ажил /Баянгол сум/	200.0	НТШ	7
4	Зоорь байгуулах /Түшиг сум/	100.0	ХА	5
5	Хашаажуулах төсөл /Сүхбаатар сум, 1-р баг/	25.0	ХА	3
6	Ухаалаг системтэй 3 гүний худаг байгуулах /Сүхбаатар сум, 5-р баг/	100.0	ХА	3
7	Гэрэлт цогцолборын засварын ажил /Сүхбаатар сум/	39.0	ХА	2
8	Сант суманд цэвэр усны шугамын засварын 2-р хэсгийн ажил	80.0	ХА	4
	Дүн	894.0	-	17

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.1.5 Худалдан авах ажиллагааны тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулж, 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу гүйцэтгэгчийг цахим системийг ашиглан зохион байгуулан, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

2.1.6 160.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд ганц оролцогч санал ирүүлсэн гэх үндэслэлээр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доош хоногт гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 29.2¹⁵ дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн нэгдсэн эмнэлэгт засвар хийх”
- 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Соёлын төвд лед дэлгэц авах /Сант сум/”
- 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Соёлын төвд лед дэлгэц авах /Сайхан сум, Номгон тосгон/”
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Явган хүний замын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/”

2.1.7 Аймгийн ОНӨГ нь цахим худалдан авах ажиллагааны архивын баримтад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, хүлээн авсан баримт материалыг хавсаргаагүй нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 49.2¹⁶, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим

¹⁵ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

¹⁶ Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ: ... 49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг.

тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.2¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

2.1.8 Тайлангийн 1.2.4 дэх хэсэгт дурдсанаар ОНХС-ийн чиг үүрэгт үл хамаарах 915.8 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 865.8 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх *“Коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах”- төсөл, арга хэмжээнд 620.8 сая төгрөг, Баруунбүрэн суманд “Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих”-д 100.0 сая төгрөг, Шаамар сумын сургуулийн засварын зураг төсөвт 15.0 сая төгрөг/ зорилго бүхий төсөл, арга хэмжээнд 735.8 сая төгрөг,*
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал /Аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт хамрын дурангийн тоног төхөөрөмж худалдан авах 80.0 сая төгрөг, аймгийн нэгдсэн эмнэлгийн засварт 50.0 сая төгрөг,-д 130.0 сая төгрөг.

2.1.9 Дараах төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд “Чанарын баталгаа 5 хувь байна” гэж заасан боловч дараах төсөл, арга хэмжээнд 9.5 сая төгрөгийн барьцаа тооцоогүй болон дутуу тооцсон байна. Үүнд:

- *“Орхон сумын дулааны шугам сүлжээ тавих” төсөл, арга хэмжээнд 4.8 сая төгрөгийн барьцаа тооцоогүй,*
- *“Ногоон байгууламж, зам талбайн тохижилт /Сайхан сум/” 5 хувь болох 13.5 сая төгрөгийг барьцаалахаас 8.8 сая төгрөгөөр тооцож барьцаалсан.*

2.1.10 Хурлын тэмдэглэл болон тооцсон төсөвгүйгээр 14 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардалд 12.7 сая төгрөг олгосон нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17¹⁸ дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-т харуулав/

2.1.11 Ковид-19 цар тахлын тархалт эрчимжсэн, барилгын материалын үнийн өсөлт, хил гааль тодорхойгүй хугацаагаар хаасантай холбогдуулан аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, гүйцэтгэлийн ажил удааширч, оны эцэст 948.7 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/414 дүгээр захирамжаар “Хөрөнгө оруулалтын барьцаа” дансанд төвлөрүүлсэн байна.

2.1.12 Өмнөх оноос он дамжсан “Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн засварын ажил”-ын санхүүжилт 36.3 сая төгрөгийг “хөрөнгө оруулалтын барьцаа” хөрөнгийн дансанд шилжүүлж, 2021 онд олгохдоо ОНХС-ийн дансаар дамжуулалгүйгээр шууд 34.5 сая төгрөг шилжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.1-д *“ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.”* гэж заасныг зөрчсөн байна.


¹⁷ Захиалагч хуулийн 49.2.1-49.2.9-д заасан баримт бичиг, материалыг тендер шалгаруулалтыг зохион байгуулж дууссанаар, хуулийн 49.2.10-т заасан баримт бичиг, гэрээг дүгнэж ажил, үйлчилгээг хүлээн авснаар зохих журмын дагуу архивлан хадгална.

¹⁸ Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

Сумдын ОНХС:

2.1.13 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр нийт 4,917.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 130 төсөл, арга хэмжээ баталснаас 2,274.6 сая төгрөгийн 74 төсөл арга хэмжээ бүрэн / гэрээний үнээр /, 1,354.8 мянган төгрөгийн 28 төсөл арга хэмжээ / гэрээний үнээр / дутуу хэрэгжиж, 1,192.5 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 4. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх үүсвэр: Аймгийн ОНХС

2.1.14 2021 онд шинээр хэрэгжүүлэх 4,584.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 3,636.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 90 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд:

- 1,608.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 1,416.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний аргаар,
- 122.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг олон нийтийн оролцоотой худалдан авалтын аргаар,
- 479.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар тус тус гүйцэтгэсэн байна.

2.1.15 Баталсан төсөвт өртөг нь хүрэлцээгүй, газрын зөвшөөрөл гараагүй, хандивын эх үүсвэр бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас 882.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 17 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2.1.16 Гүйцэтгэгчийг сонгох харьцуулалтын аргаас зайлсхийж Хушаат, Орхонтуул, Жавхлант сум нь ижил төстэй **126.0** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тус бүр 2 хуваан

төлөвлөж, шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4¹⁹, 8.5²⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- “Хушаат сумын төвлөрсөн хогийг түрж булах, хог хүлээн авах далан босгох, хашаажуулах ажил” 36.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ,
- Орхонтуул сум “Баянцогтын 2-р багийн “Туулын ундарга” зоогийн газрын дээвэр, сантехник, цахилгаан засвар хийх” 70.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ,
- Жавхлант сумын Моностой 2-р багийн хүүхдийн тоглоомын талбайн хашаа барих, талбай цементлэх, тохижилтын ажил” 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ гэх мэт.

2.1.17 Жавхлант сум нь “Зураг төсөв хийх зардал” **35.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.2²¹, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн “2. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар-Зөвлөх үйлчилгээ-20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.1.18 Тайлангийн 1.2.13 дахь хэсэгт дурдсанчлан сумдууд нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 130.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Түшиг сум удирдлагын чиг үүрэг бүхий /сумын “Ойн менежментийн төлөвлөгөө/ 5.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс гадна дараах байдлаар ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Сант сум нь аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил”-ын захиалагчийн хяналтын болон зураг төсвийн зардалд 1.3 сая төгрөг,
- “Орхон сум нь Нэгдсэн халаалтын өргөтгөлийн ажил”-ын гүйцэтгэгч Смартлифт компанид 0.9 сая төгрөгийн илүү санхүүжилт,
- Түшиг сум нь “Дулааны шугамын шинэчлэл” ажлын зураг төсвийг гүйцэтгэгч Эм Эн Эс Жи компанид 1.2 сая төгрөг илүү олгосон гэх мэт.

2.1.19 2021 онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулж, Ковид 19 цар тахалтай холбогдож гэрээт ажлууд тогтоосон хугацаанд ашиглалтад ороогүй боловч гэрээний хугацаанд өөрчлөлт оруулаагүйгээс хугацаа хэтэрсэн дараах 17.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- Ерөө сумын 2019 оны ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Буурагчин багт халуун ус барих” ажлыг гэрээт хугацаанаас 540 хоногийн дараа буюу 2021 онд улсын комисс хүлээн авсан боловч 12.9 сая төгрөгийн,
- Жавхлант сумын “Жавхлант хаалга барих” ажлыг гэрээт хугацаанаас 52 хоногоор хэтрүүлсэн боловч 0.5 сая төгрөгийн,
- Сүхбаатар сумын 6 төсөл, арга хэмжээнд 3.7 сая төгрөгийн гэх мэт.

¹⁹ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

²⁰ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

²¹ шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

2.1.20 Жавхлант, Мандал, Сүхбаатар сумд нь хурлын тэмдэглэлгүйгээр магадалшгүй ажлын зардалд 7.6 сая төгрөг олгосон нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17²² дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-т харуулав/

2.2 ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь сангийн мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.

2.2.1 Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1-д “... ОНХС-ийн хөрөнгөөр ... барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.2.2 Аудитын дүнгээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хатуу хучилттай зам, гудамж талбайн гэрэлтүүлэг тавих, гэр хорооллын айл өрхийг дулааны болон цэвэр усны шугамд холбох, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, худаг шинээр гаргах, авто зогсоол байгуулах, зоорь хүлэмж барих зэрэг олон нийтэд чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн төсөл арга хэмжээнд түлхүү байдлаар зарцуулж байгаа сайн талууд оршиж байна.

2.2.3 Нөгөө талаас ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь сангийн мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой сумдын соёлын төвд лед дэлгэц, нэгдсэн эмнэлэгт хамрын дуран, сумын эрүүл мэндийн төвд эхо аппарат, сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах, цэцэрлэг, соёлын төвүүд, сургууль, дотуур байр, аймгийн нэгдсэн эмнэлгийн урсгал засвар, сургуулийн засварын ажлын зураг төсөв хийх зэрэг зардлуудад нийт 555.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Засаг даргын нөөц сан болон эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсөвт тусган хэрэгжүүлэх коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нэг удаагийн оношлуур худалдан авах зориулалт бус арга хэмжээнд 620.8 сая төгрөг төлөвлөж, 416.4 сая төгрөг зарцуулсан байна.
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэт жижиглэсэн буюу 1.0-20.0 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй сантехникийн болон урсгал засвар, худаг, тоглоомын талбай,

²² Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

явган хүний зам зэрэг 62 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

2.2.4 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 159.4 сая төгрөгийн Ковид 19 цар тахлын нэг удаагийн түргэвчилсэн оношлуур худалдан авсан бөгөөд үүнээс 2021 оны төсвийн жилийн эцэст /2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр/ оношлуурын нөөц үүсгэх зорилгоор аймгийн Онцгой комиссын шийдвэр, “Худалдах, худалдан авах гэрээ”-г үндэслэн нийлүүлэгч байгууллагын зарлагын баримтгүй, аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэггүй төлбөрийн хүсэлт зэрэг бүрдэл дутуу анхан шатны баримтаар 91.6 сая төгрөгийг Медикал ресурс ХХК-д шилжүүлж нэг бүр нь 15.8 мянган төгрөгийн үнэ бүхий 5800 ширхэг түргэвчилсэн оношлуур худалдан авсан байна.

2.2.5 Дээрх түргэвчилсэн оношлуурыг аймгийн ЭМГ-т хүлээлгэн өгсөн боловч 2021 онд орлого аваагүй, бүртгэл тайланд тусгаагүй, анхан шатны нэгжүүдэд хуваарилалгүйгээр агуулахад хадгалж байгаад 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 29 нэгжид олгосон байна.

2.2.6 Аймаг болон Жавхлант, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хушаат, Хүдэр, Цагааннуур, Шаамар зэрэг сумдууд нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахгүй байна.

2.3.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч дараах хөрөнгүүдийг ашиглахгүй, эсвэл зориулалт бусаар ашиглаж байгаа нь хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр Шаамар суманд хэрэгжсэн 23.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хүнсний ногоо худалдаалах павильоныг өнөөг хүртэл ашиглаагүй бөгөөд 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гүний худгийг зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүйгээс худаг нь хөлдөж, хүйтний улиралд ашиглах боломжгүй байна.
- Шаамар сумын 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр 50.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ачдаг, түрдэг трактор” худалдан авсан боловч 2021 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дугуйт ачигч ковш” буюу ижил зориулалтын техник худалдан авсан байна. 2019 онд худалдан авсан 50.2 сая төгрөгийн өртөг бүхий “Ачдаг, түрдэг трактор”-ыг эвдэрсэн тул засуулах шаардлагатай гэх үндэслэлээр хувийн эзэмшлийн компанийн хашаанд хадгалж байна.
- Мөн Шаамар сумын 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр 60.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бетон зуурмагийн машин” буюу төрийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагагүй, зориулалт бус техник хэрэгсэл худалдан авч, тус сумын нутаг дэвсгэрт зам тавих үйл ажиллагаа эрхэлж буй хувийн аж ахуйн нэгжид түрээсээр ашиглуулж байна.
- Орхонтуул сумын ОНХС-аар орон нутгийн эзэмшлийн “Туулын ундарга” зоогийн газрыг засварлах ажилд 70.0 сая төгрөг зарцуулж, ашиглалтад хүлээн авсан боловч өнөөг хүртэл зориулалтын дагуу ашиглаагүй байна.

2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийн харуул хамгаалалт, ашиглалт, урсгал зардал

тодорхой бус байгаагаас эдгээр хөрөнгүүд эзэнгүйдэх, эвдэрч, гэмтэх эрсдэлтэй байна.

2.3.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон тайлангийн 3.2.5 дахь хэсэгт дурдсан 656.6 сая төгрөгийн хөрөнгүүдийг бүртгэл, тайланд тусгаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, хадгалалт, хамгаалалт сулрах эрсдэлийг үүсгэж байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БӨГӨӨД ҮР ДҮНГ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1 Төрийн аудитын байгууллагын өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна.

3.1.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

3.1.2 Аймгийн болон Алтанбулаг, Зүүнбүрэн, Сүхбаатар, Хушаат, Шаамар сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна.

3.1.3 Харин хяналт хэрэгжүүлсэн сумдын ИТХ-ын дэргэдэх хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч, эрэмбэлсэн эсэх, багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлыг хяналтад хамруулалгүйгээр зөвхөн хэрэгжилт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан эсэхийг хамруулсан байна.

3.1.4 Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, байдалтай танилцаж, зөвлөмж өгсөн гэх боловч үр дүнг ИТХ-аар хэлэлцээгүй, тухайн төсөл, арга хэмжээний нийгэмд авчрах үр өгөөжийг тооцоогүй байгаа нь ИТХ-ын зүгээс хийгдэх хяналтын үр дүнг бууруулж байна.

3.1.5 Тайлант онд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт, шалгалтыг хийгээгүй байна.

3.1.6 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн нийт 176.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 37.2²³, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор

²³ Захиалагч барилгын ажлын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2²⁴, 3.9²⁵ дэх заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Алтанбулаг сум нь 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Солдат 2-р багт хүүхдийн тоглоомын талбай барих”,
- Алтанбулаг сум нь 28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халаалтын төвийн нөөцийн гүний худаг гаргах”,
- Баруунбүрэн сум нь 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн биеийн тамирын гадна талбайг шинэчлэх”,
- Ерөө сум 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн камержуулалт”,
- Хушаат сум нь 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Даагат, Мөнхтолгой багуудын хүүхдийн тоглоомын талбай сэргээн засварлах” гэх мэт.

3.1.7 Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг болон Сангийн яамнаас хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой амьжиргаа-3 төсөл нь Монгол улсын 330 сумын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, иргэдийн ойлголт, оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.1.8 Тус төслийн 2020 оны үнэлгээгээр Сэлэнгэ аймгийн хувьд дунджаар 57 хувьтай үнэлэгдсэнээр 2021 онд 12 сум 304.1 сая төгрөгийн урамшуулал, 17 сум 136.8 сая төгрөгийн дэмжлэгийг авсан байна.

3.1.9 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй бөгөөд шат шатны ЗДТГ нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

3.1.10 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, нийт 5,655.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 албан шаардлага, 11 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1.11 Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан Алтанбулаг, Жавхлант, Орхонтуул, Сүхбаатар, Хушаат, Шаамар сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ, СТСХ, ХБТХОХ-ийн дарга нарт Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²⁶-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээр шийдвэрлэв.

²⁴ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

²⁵ “Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.”

²⁶ Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, ... хугацаанд нь биелүүлээгүй,..... албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу нэгтгэн дүгнэж, мэдээлээгүй байна

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 заалтуудын дагуу бүх сумдууд ОНХС-ийн 2021 оны хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлээгүй, ХБТХОХ нь сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.

3.2.2 Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс ОНХС-ийн 2021 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

3.2.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон дараах 656.6 сая төгрөгийн хөрөнгүүдийг ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд тусгаагүй, орлого аваагүй байна. Үүнд:

- 91.6 сая төгрөгийн өртөг бүхий 5800 ширхэг Ковид 19 өвчний түргэвчилсэн оношлуур,
- 100.0 сая төгрөгийн өртөг бүхий “Орхон сумын дулааны шугам сүлжээ”,
- 100.0 сая төгрөгийн өртөг бүхий “Явган хүний зам, гэрэлтүүлэг” /Сайхан сум, Номгон тосгон/,
- 50.0 сая төгрөгийн өртөг бүхий “Гүний худаг гаргах” /Шаамар сум, 2-р баг/,
- 65.0 сая төгрөгийн өртөг бүхий “Цахилгааны эх үүсвэрийн шугам татах /Шаамар сум/ гэх мэт.
- 250.0 сая төгрөгийн өртөг бүхий Сүхбаатар сумын Хуримын ордны хүчитгэх, засварын ажил

3.2.4 Аудитын явцад Сангийн сайдын 2018 оны 228 / 2021 оны төлөвлөлтөд мөрдөх / 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлийг ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн жилийн батлагдсан төсөв, гэрээний дүн, санхүүжилт, зарцуулалт, санал өгсөн иргэдийн тоо, гүйцэтгэгчийн тоо гэсэн 6 төрлийн мэдээллийг огт оруулаагүй,
- Сумдын ОНХС-ийн батлагдсан төсөв 2,984.6 сая төгрөг, гэрээний дүн 1,128.3 сая төгрөг, санхүүжилт 124.0 сая төгрөг, зарцуулалт 907.2 сая төгрөг, санал өгсөн иргэдийн тоо 5835, гүйцэтгэгчийн тоо 70 гэсэн мэдээллийг оруулсан байсан.

3.2.5 Бид аудитын явцад холбогдох албан тушаалтнуудаар 2021 оны мэдээллийг системд нөхөж оруулуулах арга хэмжээ авсны үр дүнд 2022 оны 06 дугаар сарын 05-ны байдлаар дараах үр дүнд хүрч, өөрчлөгдсөн байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн батлагдсан төсөв 5,814.5 сая төгрөг, гэрээний дүн 22.8 сая төгрөгийн мэдээлэл оруулж, бусад 4 мэдээллийг оруулаагүй,
- Сумдын ОНХС-ийн батлагдсан төсөв 3,039.7 сая төгрөг, гэрээний дүн 2,554.5 сая төгрөг, санхүүжилт 260.0 сая төгрөг, зарцуулалт 1,723.7 сая төгрөг, санал өгсөн

иргэдийн тоо 86,229 / төсөл арга хэмжээнд давхардсан тоогоор /, гүйцэтгэгчийн тоо 49 гэсэн мэдээллийг оруулсан байна.

3.2.6 Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд оруулаагүй байхад тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2018 оны 228, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтуудыг зөрчиж байна.

3.2.7 Аудитын явцад Шилэн дансны тухай хуулийн дагуу ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны холбогдох мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- *Аймгийн ОНХС-ийн мэдээлбэл зохих 2 төрлийн 14 мэдээллийг байршуулахаас 8 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг /ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 7-12 дугаар сар/ хугацаа хоцроож мэдээлсэн байна.*
- *Сумдын ОНХС-ийн мэдээлбэл зохих 2 төрлийн 238 мэдээллээс 182 мэдээллийг хугацаанд нь, 55 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол Сант сумын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 2021 оны 11 дүгээр сарын мэдээллийг огт мэдээлээгүй байна.*

3.2.8 “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хийж гүйцэтгэх” гэрээнд гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн тайлан, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаар заасан боловч мэдээлэл байршуулалт хангалтгүй байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар аймаг, сумдын дүнгээр нийт 8,500.1 сая төгрөгийн зөрчил илэрч, 2.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 8,498.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Төлбөрийн акт:

- Орхон, Түшиг сумд нь гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2.1 сая төгрөг илүү олгосон.

Албан шаардлага:

Аймгийн ОНХС: / 6,204.4 сая төгрөгийн зөрчил / зөрчил давхардсан төсөл, арга хэмжээг нэгтгэсэн /

- Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 1,727.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,
- ОНХС-ийн хөрөнгөөр удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий 735.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр 130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн,

- Зураг, төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй 2,932.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулсан.
- 2 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан 9.5 сая төгрөгийн чанарын баталгааг барьцаалаагүй,
- Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр аймгийн ОНХС-аас 12.7 сая төгрөгийг олгосон,
- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 91.6 сая төгрөгийн өртөг бүхий Ковид-19 өвчний түргэвчилсэн оношлуур худалдан авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй,
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 565.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,
- Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан болон албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

Сумдын ОНХС: /2,293.6 сая төгрөгийн зөрчил/ зөрчил давхардсан төсөл, арга хэмжээг нэгтгэсэн /

- Ерөө, Орхонтуул, Сайхан сумд нь иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 169.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,
- Түшиг сум нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 5.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн,
- Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант сумд нь ажлын зураг, төсөв, тавилгын үнийн тооцоо судалгаагүйгээр 61.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- 12 сум нийт 1,695.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа хийлгэсэн,
- Жавхлант, Орхонтуул, Хушаат сумд нь нийт 126.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг 2 хуваан төлөвлөж, худалдан авах ажиллагааг харьцуулалтын болон шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- Жавхлант сум нь “Зураг төсөв хийх зардал” 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн,
- Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр сумын ОНХС-аас 7.6 сая төгрөгийг олгосон,
- Алтанбулаг, Баруунбүрэн, Ерөө, Хушаат сумд нь нийт 176.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний ажлын явц болон гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй,
- 17.1 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон,

- Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан болон албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн 6 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэрээс бүрэн төвлөрүүлэхээр төлөвлөөгүй байна.
2. Зарим сумд нь иргэн, аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан байна.
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бүх төсөл, арга хэмжээг иргэдийн санал авалгүйгээр төлөвлөж, баталсан байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр буюу зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
5. ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь сангийн мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.
6. Аймгийн болон зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.
8. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй бөгөөд үр дүнг тайлагнаагүй, холбогдох байгууллагуудад мэдээлээгүй байна.
9. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна.
10. ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд оруулаагүй байхад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон байна.
11. ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны холбогдох мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Иргэдийн санал авсан, зураг төсөв, тооцоо судалгаа, магадлал хийгдсэн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, батлах.

2. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд ИТХ-ын дэргэдэх хороодоор хяналт хийлгэж, дүнг хэлэлцэж, шийдвэрлэж байх.
3. ОНХС-ийн хөрөнгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг жил бүр ИТХ-аар хэлэлцэж байх.


Аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээс бүрэн бүрдүүлж, төвлөрүүлэхээр төлөвлөх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх.
2. “Малын тоо толгойн албан татвар”-ыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр байхаар төлөвлөж, хэрэгжүүлэх.
3. ОНХС-ийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөх, иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байх.
4. ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн болон төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр бус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөж, ИТХ-д өргөн мэдүүлж байх.
5. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлж, ИТХ-д оруулж хэлэлцүүлэх.

Аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарт:

1. Төсөл, арга хэрэгжилтэд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж байх.
2. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл, тайланд бүрэн тусган, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж байх.
3. ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд оруулсны үндсэн дээр санхүүжилтийг олгох.
4. ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны холбогдох мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Т.БОЛОР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2223

2022.06.03 № 01/721
танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын улмаас 2021 оны ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авч, эрэмбэлэх ажил зохион байгуулагдаагүй бөгөөд уг цар тахал Сэлэнгэ аймагт 2020 оны эцсээр өргөн тархсантай холбогдуулж Коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах төсөл арга хэмжээний 620,8 сая төгрөгийн аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгаж 416,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын баталсан төсвийн хүрээнд Аймгийн онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 71 дүгээр хуралдаанаар түргэвчилсэн оношлуур худалдан авах үүргийг Эрүүл мэндийн газрын даргад үүрэг болгосны дагуу “Медикал Ресурс” компанитай гэрээ байгуулж, нийт 91,6 сая төгрөгийн үнэ бүхий 5800 ширхэг оношлуурыг худалдан авч нөөц үүсгэсэн.

Цаашид аудитаар өгсөн нөхөн төлбөрийн болон акт зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Ж.САЙНЦОГ

C:\user\albanbichig2021\tom toot A4

430810693

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргаас тайлангийн төсөлд засвар оруулах тухай санал ирээгүй тул тайланд өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэв.



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 1104

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ-ын дарга /Б.Нарантуяа/, Засаг дарга /Н.Лхагвадорж/ болон сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Т.Болор/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА

- 018010013

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
Шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ:						
1	Сэлэнгэ аймаг	Сайханы Хөтөлийн шилэн гүүрний суурийн ажил	2020	2021	470.0	470.0
2	Сэлэнгэ аймаг	Хэрх, Түнхэл тосгонд хатуу хучилттай авто зам барих	2020	2021	500.0	500.0
3	Сэлэнгэ аймаг	Сант суманд цэвэр усны магистрал шугам шинэчлэх	2020	2021	160.0	43.5
4	Сэлэнгэ аймаг	Сүхбаатар сумын Хуримын ордонгийн хүчитгэх, засварын ажил	2020	2021	250.0	250.0
5	Сэлэнгэ аймаг	Атрын 60 жилийн ойн арга хэмжээний зардал	2019	2021	120.0	120.0
Нийт шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ						1,383.5
Шинээр эхлэх төсөл, арга хэмжээ:						
1	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-т насос авах	2020	2021	150.0	150.0
2	Сэлэнгэ аймаг	Шилэн гүүр барих	2020	2021	700.0	700.0
3	Сэлэнгэ аймаг	Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох /Алтанбулаг сум/	2021	2021	100.7	100.7
4	Сэлэнгэ аймаг	Орхон сумын дулааны шугам сүлжээ тавих	2021	2021	100.0	100.0
5	Сэлэнгэ аймаг	Дулаан, цэвэр усны шугам татах /Сүхбаатар сум, 8-р баг/	2021	2021	100.0	100.0
6	Сэлэнгэ аймаг	Сумын төвийн гэрэлтүүлэг, гэрэлт гудамж байгуулах /Ерөө сум/	2021	2021	55.0	55.0
7	Сэлэнгэ аймаг	Гудамж, талбайн гэрэлтүүлэг /Мандал сум/	2021	2021	750.0	750.0
8	Сэлэнгэ аймаг	Зоорь байгуулах /Түшиг сум/	2021	2021	100.0	100.0
9	Сэлэнгэ аймаг	Явган хүний зам, гэрэлтүүлэг /Сайхан сум, Номгон тосгон/	2021	2021	100.0	100.0
10	Сэлэнгэ аймаг	Сумын төвийн хатуу хучилттай замын үргэлжлэл /Цагааннуур сум/	2021	2021	200.0	200.0
11	Сэлэнгэ аймаг	Хашаажуулах төсөл /Сүхбаатар сум, 1-р баг/	2021	2021	25.0	25.0
12	Сэлэнгэ аймаг	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Сүхбаатар сум, 7-р баг/	2021	2021	20.0	20.0
13	Сэлэнгэ аймаг	Малын худаг шинээр барих /Жавхлант сум/	2021	2021	91.0	91.0
14	Сэлэнгэ аймаг	Гудамж, талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, засварлах /Жавхлант сум/	2021	2021	51.0	51.0
15	Сэлэнгэ аймаг	Дулааны шугам татах /Сүхбаатар сум, 4-р баг/	2021	2021	100.1	100.1
16	Сэлэнгэ аймаг	Ухаалаг системтэй 3 гүний худаг байгуулах /Сүхбаатар сум, 5-р баг/	2021	2021	100.0	100.0
17	Сэлэнгэ аймаг	Орхонтуул сум үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ой угтаж баяр наадмын талбай байгуулах /Орхонтуул сум/	2021	2021	150.0	150.0
18	Сэлэнгэ аймаг	Могойтын аманд зам, гэрэлтүүлэг тавих /Сүхбаатар сум, 2-р баг/	2021	2021	200.0	200.0
19	Сэлэнгэ аймаг	Өрхийн эмнэлэг, цагдаа, ахмад, багийн нэгдсэн байр барих /Сүхбаатар сум, 3-р баг/	2021	2021	200.0	200.0
20	Сэлэнгэ аймаг	Гудамжны гэрэлтүүлэг /Сүхбаатар сум, 3-р баг/	2021	2021	100.0	100.0
21	Сэлэнгэ аймаг	Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих /Баруунбүрэн сум/	2021	2021	100.0	100.0
22	Сэлэнгэ аймаг	Зоорь байгуулах (200 тн) /Хушаат сум/	2021	2021	95.0	95.0
23	Сэлэнгэ аймаг	Ногоон байгууламж, зам талбайн тохижилт /Сайхан сум/	2021	2021	270.0	270.0
24	Сэлэнгэ аймаг	Гүний худаг гаргах /Шаамар сум, 2-р баг/	2021	2021	50.0	50.0
25	Сэлэнгэ аймаг	Зоорь байгуулах /Хүдэр сум/	2021	2021	100.0	100.0
26	Сэлэнгэ аймаг	Жишиг гудамж байгуулах, зам тавих /Орхонтуул сум, Рашаант тосгон/	2021	2021	100.0	100.0
27	Сэлэнгэ аймаг	Сүхбаатар сумын 4-р сургуулийн хажууд авто зогсоол байгуулах	2021	2021	50.0	50.0
28	Сэлэнгэ аймаг	Цахилгааны эх үүсвэрийн шугам татах /Шаамар сум/	2021	2021	65.0	65.0
29	Сэлэнгэ аймаг	Хүнсний ногоо худалдаалах павильон байгуулах /Шаамар сум/	2021	2021	23.0	23.0

30	Сэлэнгэ аймаг	Ухаалаг худгийн төхөөрөмж суурьлуулах /Цагааннуур сум/	2021	2021	25.0	25.0
31	Сэлэнгэ аймаг	Сумын эмнэлэгт эхо аппарат авах /Ерөө сум/	2021	2021	33.0	33.0
32	Сэлэнгэ аймаг	Камержуулалт /Сүхбаатар сум, 7-р баг/	2021	2021	80.0	80.0
33	Сэлэнгэ аймаг	Сайн үүлдэрийн хээлтүүлэгч малаар хангах /Сант сум/	2021	2021	40.0	40.0
34	Сэлэнгэ аймаг	Коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах	2021	2021	344.8	344.8
35	Сэлэнгэ аймаг	Дугуйт ачигч ковш худалдан авах /Шаамар сум/	2021	2021	90.0	90.0
36	Сэлэнгэ аймаг	Коронавирусын тархалтыг хумих, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах	2021	2021	276.0	276.0
37	Сэлэнгэ аймаг	Статистикийн хэлтэст автомашин авах	2021	2021	50.0	50.0
38	Сэлэнгэ аймаг	Соёлын төвд лед дэлгэц авах /Сант сум/	2021	2021	30.0	30.0
39	Сэлэнгэ аймаг	Соёлын төвд лед дэлгэц авах /Сайхан сум, Номгон тосгон/	2021	2021	30.0	30.0
40	Сэлэнгэ аймаг	Хамрын дурангийн тоног төхөөрөмж худалдан авах /Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг/	2021	2021	80.0	80.0
41	Сэлэнгэ аймаг	Аймгийн сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021	2021	150.0	150.0
42	Сэлэнгэ аймаг	Зүүнбүрэн сумын дотор зам засвар	2021	2021	100.0	100.0
43	Сэлэнгэ аймаг	Уурын зуухны засварын ажил /Баянгол сум/	2021	2021	200.0	200.0
44	Сэлэнгэ аймаг	Өрхийн эмнэлгийн их засвар /Сүхбаатар сум, 1-р баг/	2021	2021	75.0	75.0
45	Сэлэнгэ аймаг	Соёлын төвийн засварын ажил /Ерөө сум/	2021	2021	30.0	30.0
46	Сэлэнгэ аймаг	Цэцэрлэгийн засвар /Ерөө сум, Бугант тосгон/	2021	2021	82.0	82.0
47	Сэлэнгэ аймаг	Шандын давааны зам засвар /Сант сум/	2021	2021	60.0	60.0
48	Сэлэнгэ аймаг	Явган хүний замын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/	2021	2021	50.0	50.0
49	Сэлэнгэ аймаг	Аймгийн нэгдсэн эмнэлэгт засвар хийх	2021	2021	50.0	50.0
50	Сэлэнгэ аймаг	Сургуулийн сантехникийн их засвар /Сайхан сум/	2021	2021	35.0	35.0
51	Сэлэнгэ аймаг	Ахмадын өргөө, сувилал, хүүхэд хамгаалах байрны дээврийн засварын ажил	2021	2021	100.0	100.0
52	Сэлэнгэ аймаг	16 айлын орон сууцны гадна дээврийн засварын ажил /Сүхбаатар сумын Ган зам 7-р баг/	2021	2021	20.0	20.0
53	Сэлэнгэ аймаг	Гэрэлт цогцолборын засварын ажил /Сүхбаатар сум/	2021	2021	39.0	39.0
54	Сэлэнгэ аймаг	Ахмадын байрны засварын ажил /Сант сум/	2021	2021	30.0	30.0
55	Сэлэнгэ аймаг	Сургуулийн засварын ажлын зураг төсөв /Шаамар сум/	2021	2021	15.0	15.0
56	Сэлэнгэ аймаг	Сант суманд цэвэр усны шугамын засварын 2-р хэсгийн ажил	2021	2021	80.0	80.0
57	Сэлэнгэ аймаг	Алтанбулаг сумын уурын зуухны шинэчлэл	2021	2021	100.0	100.0
58	Сэлэнгэ аймаг	Дотуур байрны засварын ажил /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Спорт сургууль/	2021	2021	60.0	60.0
59	Сэлэнгэ аймаг	Дотуур байрны засварын ажил /Сүхбаатар сум 1-р сургууль/	2021	2021	40.0	40.0
60	Сэлэнгэ аймаг	Ухаалаг худаг, шугамын засварын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/	2021	2021	50.0	50.0
61	Сэлэнгэ аймаг	Баяр наадмын зардал	2021	2021	100.0	100.0
62	Сэлэнгэ аймаг	Баяр наадмын зардал	2021	2021	100.0	100.0
Нийт шинээр эхлэх төсөл, арга хэмжээ						6,890.6
Нийт төсөл, арга хэмжээ						8,274.1

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	Сэлэнгэ аймаг	Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох /Алтанбулаг сум/	2021	2021	100.7	100.7
2	Сэлэнгэ аймаг	Орхон сумын дулааны шугам сүлжээ тавих	2021	2021	100.0	100.0
3	Сэлэнгэ аймаг	Дулаан, цэвэр усны шугам татах /Сүхбаатар сум, 8-р баг/	2021	2021	100.0	100.0
4	Сэлэнгэ аймаг	Сумын төвийн гэрэлтүүлэг, гэрэлт гудамж байгуулах /Ерөө сум/	2021	2021	55.0	55.0
5	Сэлэнгэ аймаг	Гудамж, талбайн гэрэлтүүлэг /Мандал сум/	2021	2021	750.0	750.0
6	Сэлэнгэ аймаг	Явган хүний зам, гэрэлтүүлэг /Сайхан сум, Номгон тосгон/	2021	2021	100.0	100.0
7	Сэлэнгэ аймаг	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Сүхбаатар сум, 7-р баг/	2021	2021	20.0	20.0
8	Сэлэнгэ аймаг	Малын худаг шинээр барих /Жавхлант сум/	2021	2021	91.0	91.0
9	Сэлэнгэ аймаг	Гудамж, талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, засварлах /Жавхлант сум/	2021	2021	51.0	51.0
10	Сэлэнгэ аймаг	Дулааны шугам татах /Сүхбаатар сум, 4-р баг/	2021	2021	100.1	100.1
11	Сэлэнгэ аймаг	Гудамжны гэрэлтүүлэг /Сүхбаатар сум, 3-р баг/	2021	2021	100.0	100.0
12	Сэлэнгэ аймаг	Зоорь байгуулах (200 тн) /Хушаат сум/	2021	2021	95.0	95.0
13	Сэлэнгэ аймаг	Ногоон байгууламж, зам талбайн тохижилт /Сайхан сум/	2021	2021	270.0	270.0
14	Сэлэнгэ аймаг	Гүний худаг гаргах /Шаамар сум, 2-р баг/	2021	2021	50.0	50.0
15	Сэлэнгэ аймаг	Зоорь байгуулах /Хүдэр сум/	2021	2021	100.0	100.0
16	Сэлэнгэ аймаг	Жишиг гудамж байгуулах, зам тавих /Орхонтуул сум, Рашаант тосгон/	2021	2021	100.0	100.0
17	Сэлэнгэ аймаг	Цахилгааны эх үүсвэрийн шугам татах /Шаамар сум/	2021	2021	65.0	65.0
18	Сэлэнгэ аймаг	Хүнсний ногоо худалдаалах павильон байгуулах /Шаамар сум/	2021	2021	23.0	23.0
19	Сэлэнгэ аймаг	Ухаалаг худгийн төхөөрөмж суурьлуулах /Цагааннуур сум/	2021	2021	25.0	25.0
20	Сэлэнгэ аймаг	Камержуулалт /Сүхбаатар сум, 7-р баг/	2021	2021	80.0	80.0
21	Сэлэнгэ аймаг	Сайн үүлдэрийн хээлтүүлэгч малаар хангах /Сант сум/	2021	2021	40.0	40.0
22	Сэлэнгэ аймаг	Аймгийн сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021	2021	150.0	150.0
23	Сэлэнгэ аймаг	Зүүнбүрэн сумын дотор зам засвар	2021	2021	100.0	100.0
24	Сэлэнгэ аймаг	Өрхийн эмнэлгийн их засвар /Сүхбаатар сум, 1-р баг/	2021	2021	75.0	75.0
25	Сэлэнгэ аймаг	Соёлын төвийн засварын ажил /Ерөө сум/	2021	2021	30.0	30.0
26	Сэлэнгэ аймаг	Цэцэрлэгийн засвар /Ерөө сум, Бугант тосгон/	2021	2021	82.0	82.0
27	Сэлэнгэ аймаг	Шандын давааны зам засвар /Сант сум/	2021	2021	60.0	60.0
28	Сэлэнгэ аймаг	Явган хүний замын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/	2021	2021	50.0	50.0
29	Сэлэнгэ аймаг	Аймгийн нэгдсэн эмнэлэгт засвар хийх	2021	2021	50.0	50.0
30	Сэлэнгэ аймаг	Сургуулийн сантехникийн их засвар /Сайхан сум/	2021	2021	35.0	35.0
31	Сэлэнгэ аймаг	Ахмадын өргөө, сувилал, хүүхэд хамгаалах байрны дээврийн засварын ажил	2021	2021	100.0	100.0
32	Сэлэнгэ аймаг	16 айлын орон сууцны гадна дээврийн засварын ажил /Сүхбаатар сумын Ган зам 7-р баг/	2021	2021	20.0	20.0
33	Сэлэнгэ аймаг	Ахмадын байрны засварын ажил /Сант сум/	2021	2021	30.0	30.0
34	Сэлэнгэ аймаг	Дотуур байрны засварын ажил /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Спорт сургууль/	2021	2021	60.0	60.0
35	Сэлэнгэ аймаг	Дотуур байрны засварын ажил /Сүхбаатар сум 1-р сургууль/	2021	2021	40.0	40.0
36	Сэлэнгэ аймаг	Баяр наадмын зардал	2021	2021	100.0	100.0
Зураг төсөв, тооцоо судалгааг батлуулсны дараа хийгдсэн төсөл, арга хэмжээ					3,397.8	3,397.8

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	Алтанбулаг сум	Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх	2021	2021	50.0	50.0
2	Алтанбулаг сум	Уурын зуухны зураг төсөв хийлгэх	2021	2021	20.0	20.0
3	Алтанбулаг сум	Халаалтын төвийн нөөцийн гүний худаг гаргах	2021	2021	28.0	28.0
4	Баянгол сум	Гэр хорооллын гудамжны цамхагт гэрэлтүүлэг	2021	2021	98.0	98.0
5	Ерөө сум	Ерөө гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	2021	2021	60.0	60.0
6	Ерөө сум	Гэрэлт гудамж /хуучин гэрэлтүүлэг дээр нэмэх/	2021	2021	10.0	10.0
7	Ерөө сум	Тоглоомын талбай /Буурагчин багт/	2021	2021	55.0	55.0
8	Жавхлант сум	Жавхлант хаалга барих ажил	2021	2021	20.0	20.0
9	Жавхлант сум	Моностой 2-р багийн хүүхдийн тоглоомын талбайн хашаа барих, талбай цементлэх ажил	2021	2021	10.0	10.0
10	Жавхлант сум	Моностой 2-р багийн хүүхдийн тоглоомын талбайг тохижилтын ажил	2021	2021	10.0	10.0
11	Зүүнбүрэн сум	Сумын төвд хатуу хучилттай зам тавих	2021	2021	69.7	69.7
12	Мандал сум	Хүүхдийн тоглоомын талбай барих	2021	2021	400.0	400.0
13	Мандал сум	Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх	2021	2021	400.0	400.0
14	Орхон сум	Сумын төвийн нэгдсэн халаалтын өргөтгөлийн ажил	2021	2021	77.1	77.1
15	Орхонтуул сум	Рашаант тосгоны хогийн цэгийн тохижилт	2021	2021	40.0	40.0
16	Орхонтуул сум	Баянцогт 2-р багт хүнсний ногооны зоорь барих	2021	2021	80.0	80.0
17	Орхонтуул сум	Хонгор овоо 3-р багт бэлчээрийн худаг гаргах	2021	2021	12.2	12.2
18	Орхонтуул сум	Хонгор-овоо 3-р багт мал угаалгын ванн барих	2021	2021	15.0	15.0
19	Орхонтуул сум	Баянцогтын 2-р багт "Ёслол хүндэтгэлийн өргөө" барих	2021	2021	31.2	31.2
20	Орхонтуул сум	Рашаант тосгоны гэрэлтүүлгийн засварлах	2021	2021	20.0	20.0
21	Орхонтуул сум	Баянцогтын 2-р багийн "Туулын ундарга" зоогийн газрын дээвэр, сантехникийн засвар хийх	2021	2021	50.0	50.0
22	Орхонтуул сум	Баянцогтын 2-р багийн гэрэлтүүлгийг засварлах	2021	2021	15.0	15.0
23	Сүхбаатар сум	8-р багийн 1-р хэсэгт хүүхдийн тоглоомын талбай	2021	2021	30.0	30.0
24	Сүхбаатар сум	4-р багийн 2-р хэсэгт хүүхдийн тоглоомын талбай	2021	2021	30.0	30.0
25	Сүхбаатар сум	1-р цэцэрлэгийн хашаанд хүүхдийн тоглоом нэмэгдүүлэх тохижуулах	2021	2021	10.0	10.0
26	Сүхбаатар сум	3-р багт үерийн далангийн гүүр барих	2021	2021	30.4	30.4
27	Сүхбаатар сум	6-р багт гэрэлтүүлэг	2021	2021	8.0	8.0
28	Хушаат сум	Сүү, цагаан идээ боловсруулах цехийн засвар үйлчилгээ	2021	2021	15.9	15.9
29	Хушаат сум	Хушаат сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалт	2021	2021	12.0	12.0
30	Хушаат сум	Хушаат сумын төвлөрсөн хогийг түрж булах, хог хүлээн авах далан босгох, хашаажуулах ажил	2021	2021	36.0	36.0
31	Хушаат сум	Даагат, Мөнхтолгой багуудын хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах	2021	2021	18.0	18.0
32	Түшиг сум	1,2 дугаар багт шороон зам засвар өргөтгөл	2021	2021	50.0	50.0
33	Цагааннуур сум	2-р багийн хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах	2021	2021	35.6	35.6
Зураг төсөв, тооцоо судалгааг батлуулсны дараа хийгдсэн төсөл, арга хэмжээ					1,847.1	1,847.1
34	Алтанбулаг сум	Солдат 2-р багт хүүхдийн тоглоомын талбай хийх	2021	2021	20.0	20.0
35	Алтанбулаг	Хүүхдийн тоглоом /цэцэрлэгүүд/	2021	2021	20.0	20.0
36	Баруунбүрэн	Сургуулийн биеийн тамирын гадна талбайг шинэчлэх	2021	2021	80.0	80.0
37	Баруунбүрэн	Жаргалант эхийн булгийг хашаажуулах	2021	2021	6.0	6.0

38	Баруунбүрэн	Асгатын эхийн булгийг хашаажуулах	2021	2021	6.0	6.0
39	Баруунбүрэн	Даваагийн булагт гүний худаг гаргах	2021	2021	10.0	10.0
40	Ерөө	Сумын төвийн камержуулалт	2021	2021	30.0	30.0
41	Жавхлант	Хайрган хучилттай зам бетонон болгох ажил	2021	2021	19.8	19.8
Зураг төсөв, тооцоо судалгааг огт хийлгээгүй төсөл, арга хэмжээ					191.8	191.8
Нийт					2,038.9	2,038.9

Магадалшгүй ажлын тэмдэглэл үйлдээгүй төсөл арга хэмжээ

№	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Магадалшгүй ажлын баримт			
				Дүн	Тэмдэглэл	Акт	Зураг төсөв
1	Аймгийн ОНХС	Цэцэрлэгийн засвар /Ерөө сум, Бугант тосгон/	82.0	2.0	Үгүй	2021.10.04	Үгүй
2		Хүнсний ногоо худалдаалах павильон байгуулах /Шаамар сум/	23.0	0.6	Тийм	2021.12.01	Үгүй
3		Орхон сумын дулааны шугам сүлжээ тавих	100.0	1.6	Тийм	2021.07.20	Үгүй
4		Сант суманд цэвэр усны магистрал шугам шинэчлэх	43.5	2.6	Үгүй	2020.10.15	Үгүй
5		Явган хүний замын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/	50.0	0.7	Тийм	2021.10.13	Үгүй
6		Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох /Алтанбулаг сум/	100.7	1.7	Үгүй	2021.11.20	Тийм
7		Сумын төвийн гэрэлтүүлэг, гэрэлт гудамж байгуулах /Ерөө сум/	55.0	0.9	Үгүй	2021.08.16	Тийм
8		Явган хүний зам, гэрэлтүүлэг /Сайхан сум, Номгон тосгон/	100.0	1.6	Үгүй	2021	Тийм
9		Дотуур байрны засварын ажил /Сүхбаатар сум 1-р сургууль/	40.0	0.7	Үгүй	2021.10.18	Тийм
10		Хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Сүхбаатар сум, 7-р баг/	20.0	0.3	Үгүй	2021.09.29	Тийм
11	Жавхлант	Жавхлант хаалга барих ажил	20.0	0.3	Үгүй	2021.08.16	Тийм
12	Мандал	Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх.	400.0	6.7	Үгүй	2021.10.12	Тийм
13	Сүхбаатар	4-р багт хүүхдийн тоглоомын талбай	27.5	0.2	Үгүй	2021.04.10	Тийм
14		5-р багт хүүхдийн тоглоомын талбай	27.5	0.4	Үгүй	2021.11.01	Тийм
		Нийт дүн	1,717.2	30.2	-	-	-